

Тууль хаялцах зан үйл²

Энэхүү судалгаа нь Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад орсон тууль хайлах зан үйлийн нарийн ёс дэгийг судалж, соёлын өвийг сэргээн таниулах, уламжлуулан үлдээх үйлст бага боловч хувь нэмэр оруулахыг зорьсон юм.

Тиймээс ЮНЕСКО-д бүртгэлтэй Монголын тууль хайлах зан үйлд хамаарах “Тууль хаялцах” хэмээн өмнө нь хараахан дурдагдаж, судлагдаж байгаагүй зан үйлийг Монгол ардын аман зохиолын бусад төрөл зүйлтэй харьцуулан судлахаар шийдсэн билээ.

Уг зан үйл нь Монголын олон угсаатанд буй харилцаа шүлгийн төрөл зүйлтэй холбоотой байгаа нь эртнээс улбаатай хэмээн үзэж болохын нэгэн дохио юм.

Abstract

“Debate epic” custom

The purpose of this research is to contribute to the List of Mongolian Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding Mongolian Epics rituals to narrow rule study and re-presentation of Cultural Heritage and leave a tradition of major.

Therefore the study related the traditional is cisled in UNESCO Mongolian Epic named “Tuuli khayaltsakh” – “Debate epic” whice has not study been the died yet.

This ancient can be considered observed in many other of the Mongolian ethnics, poems.

Өнөө үед соёлын өвийг сэргээх, хойч үедээ өвлүүлэх, уламжлуулан үлдээх ажил эрчимтэй өрнөж байна. Уг ажилд бага боловч хувь нэмэр оруулахын үүднээс соёлын биет бус өвийн зүйлд хамаарах “тууль хаялцах” хэмээх өмнө нь хараахан дурдагдаж, судлагдаж байгаагүй зан үйлийн талаар илтгэл хэлэлцүүлэхээр шийдлээ. Уг зан үйл нь мартагдаж гээгдсэн мэт байна. Тиймээс Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад орсон тууль-ийн судалгаанд хувь нэмэр оруулах нь одоогийн залуус бидний хүлээх хүндтэй үүргийн нэг хэмээн санаж, “тууль хаялцах” зан үйлийг монгол ардын аман зохиолын бусад төрөл зүйлтэй харьцуулан судлахаар шийдсэн билээ.

¹ МУИС-ийн хэл шинжлэлийн магистрант. 2015 он

² Билгүүнчимэг М. “Тууль хаялцах зан үйл” Mongolia and Northeast Asian Studies сэтгүүл. Vol.1(1). эрхэлсэн Боржигин Хүсэл нар. Fukuyosha Publishing. Japan. 2015:60-65. ISSN 2189-7492

Юун түрүүн “тууль хайлах” хэмээх үгийн тухайд эрдэмтдийн бичсэн саналаас жишээ татан авч үзье.

«Монголчууд тууль хэлэхийг “хайлах” гэдэг. Хайлах нь аялуулан хэлэх гэсэн утгатай. Аялан хэлэхдээ хөгжмийн аясаар буюу энгийн хүүрнэн хайлах хоёр янз байна. Туулийг хөгжмийн аяар хайлах, хүүрнэн хайлах нь түүний шүлгийн хэмжээг таацуулан тохируулж хэлэх нэгэн нарийн журамтай байжээ»³ хэмээн эрдэмтэн П.Хорлоо тэмдэглэсэн байна. Эндээс тууль хэлэх болон тууль хайлах хэмээх хоёр зүйлийн ялгаа гарч ирж байна. Эрдэмтэн С.Дулам уг ялгааг тайлбарлахдаа “тууль хэлэх” нь хөгжмийн зэмсэгтэй юм уу эсвэл хөгжмийн зэмсэггүй жирийн хоолойгоор аялгуулахыг нэрлэдэг байхад “тууль хайлах” гэдэг нь зарим үед хөөмийлөх, дандилдах зэргээр чимж, аргил хоолойгоор хөгжмийн зэмсэгтэй хослуулан аялгуулахыг хэлдэг хэмээжээ.⁴ Мөн Дөрвөдийн туульч Д.Пэрэнлэй “Алтай хайлах” туулийн эхийг хэлж өгөхдөө “би Алтай хайлдаггүй, харин Алтайн магтаал хэлдэг”⁵ хэмээн дээрх эрдэмтний санааг улам бататгасан байна.

Дээр бичсэнтэй санал нийлж буй тул аргил хоолойгоор туулиа хайлдаг Урианхайн туульч Занын Жилхэрээр жишээ авахаар шийдлээ.

Ховд аймгийн Дуут сумын туульч Сүхийн Чойсүрэн “Жилькерийн тууль хайлах дуу нь хэдэн саахалтын газраас сонсогдохуйц үнэхээрийн хосгүй хоолойтой байсан бөгөөд түүний аялгуулан хэлэх авьяас билгийг нь бахдавч баршгүй” хэмээн дурсан ярьсан байна.⁶

Мөн энэ туульчийн тухай нутгийн өвгөн Т.Нанзад ярихдаа “Жилхэр туульч гэж ялимгүй бөгтөрдүү нуруутай шар өвгөн байсан. Мэдэхгүй тууль гэж байхгүй. Хүний аль нэрлэсэн, хүссэн туулийг ч хайлдаг байлаа. Шөнө дундаас хойш хоолой нь улам ч цээл, тунгалаг болдог сон. Хүрээний лам нар тууль хайлахдаа төмөр зуухны хавхаг дээр хэдэн чулуу тавьчихаад дуунд нь

³П. Хорлоо, *Ард түмэн, Аман зохиол*, УБ, 1987:99.

⁴Мөн тэнд, 2007:233. Иймд эдгээр нь анхандаа тууль хайлах урлагийн нэг хэсэг байгаад хожим бие даан хөгжсөн ч байж болох юм. Аргил хоолойн эрдмийг эзэмшээгүй бол тууль хайлж байгаад тооцогдохгүй, харин аялгуулан хэлж байгаа хэрэг юм гэж үздэг байна. Баруун монголын туульчдын уламжлалаар бол хөгжмийн зэмсэгтэй ч байсан аргил хоолойгоор биш бол энэ нь “тууль хэлэх” болдог байна.

⁵С. Дулам, Г. Нандинбилиг, *Монгол аман зохиолын онол*, УБ, 2007:233. /Увс аймгийн Сагил сумын Боршоо бригадын тасгийн эрхлэгч (хуучин Дөрвөд далай ханы хошуу, шангуучин ястай), 60 настай, дөрвөд өвгөн Догшины Пэрэнлэйгээс 1984 оны 7 дугаар сарын 4-нөө соронзон хальсанд бичиж авав/

⁶У. Загдсүрэн, *Монгол ардын баатарлаг туульсын учир*, УБ, 1966:10

доргиод чулуу нь бас хангинаж байсан билээ”⁷ Энэхүү дурсамжууд бол мөнөөх л тууль хайлах аргил хоолойных нь гайхамшгийг илтгэж байна.⁸

Хүүхэд ахуй цагтаа Жилькерийн тууль хайлахыг сонсож байсан нутгийн настайчуул түүний тууль хайлахад суусан газар доргих шиг болж төмөр тавгийн ёроолд тавьсан тариа чичирч хөдөлдөг, чагнаж суусан хүний бие мэргжигнэдэг хүчтэй түрлэгээр хайлдаг байсан хэмээн хуучилж⁹ буй бол Урианхайн алдарт туульч Ө.Буян “... Миний нагац ах Жилькер арван хоёр үеийн туульч хүн, арван гурав дахь үе нь би юм. Тэр гучаад тууль мэддэг байлаа. Түүнээс би арваад туулийн эхийг сурч авсан юм”¹⁰ гэсэн нь энэ алдарт туульч төрөлхийн авьяас чадвартай урын сан нь хэчнээн баялаг болохыг мэдэж болно.¹¹

Нутгийн өвгөчүүл болон үр ач нарынх нь хэлснээс үзвэл Жилькер хадаг зүүсэн хар товшуураа цаг үргэлж авч явдаг, солгой гараараа товшуурддаг байсан агаад өндөр нуруутай бөгтөрдүү шар хүн байсан гэжээ.¹²

Туульч З.Жилхэрийн товшуур одоо Ховд аймгийн музейд хадгалагдаж байна. Энэхүү товшуурын мод нь хурууны даралтаар хонхойн элэгдсэн байдгаас үзэхэд З.Жилхэр агуу туульч байсныг гэрчилж байна.¹³

Эрдэмтэн П.Хорлоо туульч Б.Авирмэдтэй ярилцсан ярилцлагаас:

- *Жилхэр багш ... тууль хайлахдаа их цартай бүдүүн хоолойтой, амьсгаагаа урт авч, их сайхан уянгалуулан товшуурынхаа аятай гоц сайхан хослуулдаг туульч байсан гэж аав минь хэлдэг байсан. Дээд туульч Жилхэр гуайн яруу хөгтэй товшуурыг нагац Ринчин нь авч, Ховд аймгийн орон нутгийг судлах музейд өгсөн байдаг гэж Авирмэд монгол тууль хайлах ёс дэг болон урианхайн туульчдын уламжлалт арга ухааныг ярьж өгсөн нь монгол тууль судлалын эрдэм ухаанд чухал хувь нэмэр болсон юм.*¹⁴ Дээрх жишээнүүд

⁷С. Дулам, Г. Нандинбилиг. 2007:235. /Ховд аймгийн Мөнххайрхан сумын (хуучин Баруун бэйсийн хошууны мянгад сумын дархад арваны хүн) урианхайн эмчийн элкэний 64 настай өвгөн Тариачийн Нанзадаас 1983-7-29-нөө Мөнххайрхан сумын төвд бичиж авсан билээ/

⁸Мөн тэнд, 2007:235.

⁹Лха. Туяабаатар, “Нэгэн зүйл туульчин,” *Аман зохиол судлал цуврал*, Т. XIX, (УБШУАХ 1995:3)

¹⁰П. Хорлоо, “Монгол туульсын судалгааны зарим нэг асуудал,” *Аман зохиол судлал цуврал*, Т. VI, УБ, 1967:10-11.

¹¹Х. Сампилдэндэв, *Монгол аман зохиолын товчоон*, УБ, 2002:219.

¹²Мөн тэнд, 2002:219.

¹³Б. Катуу, *Монгол Урианхайн аман зохиол*, УБ, 2011:45.

¹⁴ П. Хорлоо, *Монгол ардын туульс судлал III*, УБ, 2007:65.

нь туульч Занын Жилхэрийг аргил хоолойгоор туулиа хайлдаг байсныг гэрчлэх баримт болж өгч буй юм.

Мөн ийнхүү заавал аргил хоолойгоор хайлах учраас тууль хайлахын бэлтгэл зэхээ болгож, өөрийгөө урьдчилан сойдог хийгээд архи сархад, өөх тостой хурц хоол тууль хайлж байх үедээ ууж иддэггүй (гагцхүү өдөр дундын их завсарлагаар бага зэрэг хоол иднэ) явдал мөр, дэг журам нь ч мөн нарийн байна.¹⁵ Доор нэгэн сонин зан үйлийн талаар дурдъя.

Эрдэмтэн П.Хорлоогийн туульч Б.Авирмэдтэй ярилцсан ярилцлагад туульч Б. Ширэндэв, Баян-Өлгий аймгийн Булган сумын туульч Хөх Балдан нар “тууль хаялцаж байх”-ыг туульч Б.Авирмэд харсан хэмээн гарч байна. (Ярилцлагыг *Хавсралт*-аас үзнэ үү)

Үүнд Хөх Балдан туульч “Бүжин даваа хаан” хэмээх туулийг хэлж, дараа нь Ширэндэв туульч “Талын хар бодон” туулийг хайлсан бөгөөд. энэ тууль хаялцах хайлал хоёр өдөр үргэлжилж, тууль хайлж дууссаны дараа найр хийсэн талаар дурджээ.¹⁶ Уг “тууль хаялцах” хэмээх ёс дэг нь цаашид судлууштай, судалгааны эргэлтэд оруулахад зүй зохис бүхий зүйл юм.

“Тууль хаялцах” дээрх зан үйлийн нэрийн тухайд “ном хаялцах” хэмээх үгтэй холбон үзвэл Я.Цэвэлийн тольд “*ном хаялцах*” хэмээх үгийг *аль нэгэн сэдэв асуудлаар маргалдах*¹⁷ хэмээн тайлбарласан байна. *Үг өөрөө төгс бус болохоороо номын гүнзгий утгыг сайтар мэдэх тухайтад Бурханы шашинд ном хаялцдаг тусгай ёс дэг байдаг билээ. Утга гүнзгий болон нарийсах тусам үг жулдаж түүнийг илэрхийлэх чадамж нь буурдаг. Тиймээс Бурханы шашинд энэ асуудлыг арилгах зорилгоор Цанид*^{18, 19} *Чойрын ном үзэж хоорондоо ном хаялцдаг. Бурханы шашны үг хэллэгийн тодорхойлолтыг судар номд яс зааж тодорхойлсон байдаг бөгөөд түүнийг цанид гэдэг юм байна.*²⁰

¹⁵С. Дулам, Г. Нандинбилиг. 2007:236.

¹⁶П. Хорлоо. 2007:63-64.

¹⁷Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, УБ, 1966:381.

¹⁸Цанид буюу “*мэргэн ухааны уг чанар*” болох дотоод ухааны таван үндсийг судлахдаа шавь нар уул номлолын дагуу хялбарчлан зохиосон “*Ихчаа*” хэмээх сурах бичгийг голлон судалж байсан бөгөөд энэхүү зиндааг амжилттай төгссөн лам нар гавж “*бэрх арав*” хэмээх эрдмийн анхны зэрэг авдаг байжээ.

¹⁹Д. Дагвадорж, *Бурхны шашин, монгол уламжлал*, УБ, 2002:219.

²⁰www.buddhism.mn/2014.11.17

Иймд, тууль хаялцах зан үйлийг ном хаялцахтай хэт холбохгүй байсан нь дээр бөгөөд, монгол ардын аман зохиолын төрөл зүйлс болох дайралцаа үг, хуурч гартаах үг зэрэгтэй холбон үзвэл, илүү ойр дөхөм болох нь ажиглагдаж байна.

*Дайралцаан болбоос хүүхдийн өөр хоорондоо харилцан шүлэглэх тоглоом наадмын чанартай учраас жүжгийн хэлбэртэй юм. Энэ нь хүүхдийн оюун санааг нээгдүүлж үг хэлийг баяжуулах ач холбогдолтой ажээ.*²¹

Тайлбарт дээж бичигт буй дайралцаа үгийн жишээг авч үзье.

Зэ! Хэлэлцье гэвэл хэлэлцье

Хэлтэрчихээс чинь айна би

Хэрмийн сүүдэр бариад

Дутаахаас чинь айна би

Зэ! Булаалдъя гэвэл булаалдъя

Балбарчихаас чинь айна би

Баасан нүхээр шургаад

*Дутаахаас чинь айна би*²² хэмээн өөр хоорондоо харилцан дайралцаа үг хэлэлцдэг. Дээрх тууль хаялцах зан үйлд мөн үүнтэй адил, харилцан туулиа хайлалцаж байна. Иймд уг тууль хаялцах зан үйл нь эртнээс улбаатай байсан бололтой.

Буриад ардын аман зохиолд “Уг мунгаалгын дайралцаа үг” гэж буй. Жишээ татвал:

5. *Хорийн буряад холборхой*

Хооһон хүнэг мухарюухай

Хори хори хольшигоноо

Хооһон хүнэг мухаряа

Галзууд гавараатай

10. *Ганса модон түдхэлтэй*

Дуу ехэтэ тэнгэри

²¹Ш. Гаадамба, Д. Цэрэнсодном, *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*, УБ, 1978:85.

²²Д. Цэрэнсодном, *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*, УБ, 2012:339.

Дурвилга ехэтэ Худай

Хамаг түмэн Хальбан

*Хара монгол удхатан*²³... хэмээн дайралцдаг байна.

Өөлд ардын аман зохиолд яндага, хойг²⁴ хэмээх хэмээх нэгэн төрөл зүйл буй.

“Яндагалах” гэдгийн тухайд, “Өөлдөд бас хүний ухаан санаа, ой билиг, ёс суртал, соёл боловсрол, утга урлагийн хэр хэмжээг шүүмжлэн үнэлэх хэмжүүр болсоор иржээ. Тодорхойлж хэлбэл эл талын боловсролын байдлыг хэмжин өртөөлөх тусгай ёс нь яндага байсан юм. Өнгөрсний яндага яндагалах нь одоогийн шүүмжлэн өгүүлэхтэй эгээ адилхан үүрэг гүйцэтгэж байжээ”²⁵

Уг яндага нь мөн туультай холбоотой байх юм. Яндага нь дотроо оньсгын, бий бүжгийн, дууны, тууль авуулах яндага гэх мэтээр аман зохиолын бүхий л төрлийг хамрах бөгөөд цаашаа орчлонгийн дөрвөн хойг, Жангарын арван хоёр мухугал хойг ... гэх зэргийн зүйр цэцэн үг, тууль, туужилсан мухугал хайлж яндага яндагална.²⁶

Энэ нь тууль хаялцахтай дүйцэхүйц, нэгэн төрлийн хайлал болдог байна.

Дээрхээс дүгнэн үзвэл, Монголчуудын хэрэглэдэг үг бүрийн цаана далд утга нуугдаж байдаг бөгөөд хэлэх, хайлах хэмээх хоёр үг нь ч мөн “тууль” хэмээх үгтэй хоршин хэрэглэгдэхдээ өөр өөр утгыг илэрхийлэн гаргаж буй нь илт байна. Тиймээс одоо үеийн туульчид тууль хэлж байна уу, хайлж байна уу гэдэг нь нэн чухал асуудлын нэг юм. Үүнийг цаашид анхааран үзвэл зүйтэй.

Орчин үед аргил хоолойгоор хэлж байвал тууль хайлж байна гэж үзэх нь өрөөсгөл ойлголт юм. Учир нь тууль хэмээх нь тайзны урлаг болсон өнөө үед жинхэнэ туульч гэдэг ойлголт ардын авьяастнуудын дунд л үлдсэн бөгөөд, язгуур урлагийн хамтлагууд нь туульч хэмээх ойлголтод хамаарахгүй юм.

²³Ж. Цолоо, Г. Гантогтох, *Арван гурван ноёдын дуун*, УБ, 2007:451.

²⁴“Яндага” гэдэг нь шингэн буюу үйрмэг юмны багтаамжийг хэмжээлэх савыг заасан утгатай, “Хойг гэдэг нь магтаал буюу дуулал гэсэн утгайтай үг юм байна.

²⁵С. Баттулга, *Өөлд ардын аман зохиол*, УБ, 2013:70.

²⁶Мөн тэнд, 2013:70.

Энд нэгэн шинэ зүйл гарч ирж буй нь “тууль хаялцах” зан үйл юм. Уг зан үйл нь монголчуудын дайралцаа үг, хуурч гартаах үг зэрэг аман зохиолын бусад төрөл зүйлтэй холбоотой байгаа нь нэн сайшаалтай бөгөөд цаашид судалгааны эргэлтэд оруулах нь зүй ёсны хэрэг юм.

Тууль хаялцах зан үйл нь Монголын олон угсаатанд буй харилцаа шүлгийн төрөл зүйлстэй холбоотой байгаа нь уг зан үйлийг эртнээс улбаатай хэмээн үзэж болохын нэгэн дохио юм.

Иймд уг зан үйлийг сэргээн, туульчдын дунд тууль хаялцах зан үйлийг зохион байгуулж байх нь Монгол үндэсний өв соёлыг сэргээн батжуулахад онцгой хувь нэмэр оруулах юм.

Номзүй:

1. Баттулга С. *Өөлд ардын аман зохиол*. УБ. 2013.
2. Гаадамба Ш. Цэрэнсодном Д. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. УБ. 1978.
3. Дагвадорж Д. *Бурхны шашин, монгол уламжлал*. УБ. 2002.
4. Дулам С. Нандинбилиг Г. *Монгол аман зохиолын онол*. УБ. 2007.
5. Загдсүрэн У. *Монгол ардын баатарлаг туульсын учир*. УБ. 1966.
6. Катуу Б. *Монгол Урианхайн аман зохиол*. УБ. 2011.
7. Сампилдэндэв Х. *Монгол аман зохиолын товчоон*. УБ. 2002.
8. Туяабаатар Лха. “Нэгэн зүйл туульчин.” *Аман зохиол судлал цуврал. Т. XIX.* (УБШУАХ 1995)
9. Хорлоо П. *Ард түмэн, Аман зохиол*. УБ. 1987.
10. Хорлоо П. *Монгол ардын туульс судлал III*. УБ 2007.
11. Хорлоо П. “Монгол туульсын судалгааны зарим нэг асуудал.” *Аман зохиол судлал цуврал. Т. VI.* УБ. 1967.
12. Цолоо Ж. Гантогтох Г. *Арван гурван ноёдын дуун*. УБ. 2007.
13. Цэвэл Я. *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ. 1966.
14. Цэрэнсодном Д. *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. УБ. 2012.
15. Юндэнбат С. *Монгол үндэстний соёлын биет бус өвийн ховор хосгүй төрөл зүйлс*. УБ. 2011.
16. www.buddhism.mn/2014.11.17

Хавсралт

Эрдэмтэн П.Хорлоо туульч Б.Авирмэдтэй ярилцсан ярилцлагаас:

Галтмаагийн Ширэндэв ах бол 7-8 том тууль мэддэг хүн байсан. Тэр тууль хайлахдаа товшуур хөгжим товишиж, түүнийхээ аяар бүдүүн уянгат хоолойгоор туулиа хайлдаг байсан ба туулиа сонсогч олны хүслийг гүйцэтгэж буян үйлдэх, баяжих хүсэлд зориулан “Аргил цагаан өвгөн” хэмээх туулийг хэлдэг. Үр хүүхэд хүсэхэд “Наран хаан хөвгүүн” болон “Арын Өнчин Яргай” гэдэг туулийг тус тус хайлдаг гэж хэлдэг байлаа.

Бас нэг сонин юм гэвэл, Ширэндэв ах Баян-Өлгий аймгийн Булган сумын туульч Хөх Балдан гэдэг туульчтай “тууль хаялцаж байх”-ыг нь харсан. Тэр их сонин юм билээ. Тэр тууль хайлж байсан нутагт 16-17 айл байсан. Тэд тусгай гэр барьж, туульч нарыг хоёр талд нь суулгаад, өмнө нь ширээн дээр нь савтай айраг чигээ, тавагтай цагаан идээ тавьдаг юм байна билээ. Эдгээр дэг ёсыг тууль хэлүүлэхээр аваачсан айл ёсчлон биелүүлдэг юм билээ. Гэрийн эзэн Балдан туульч, Ширэндэв ах хоёрт хадаг барьж:

-Та бүхэн тууль хайлж хайрла? гэж хэлэхэд туульчид хадгийг товшууртаа уяж, зузаан эсгий дэвсгэр дээр завилан сууж, малгайгаа тэгшихэн өмсөн, товшуурын ая гаргах үеэр гэрийн эзэн тулгыг тойруулан гурван талд нь арцаар сан тавив. Товшуурын аяар туульч “Алтайн магтаал”-ыг аялгуулан эхлээд, Алиа Хонгорыг ирүүлээд мордох үеэр гэрийн эзэгтэй гадаа гарч:

-Баян Алтай минь! гэж залбиран, Алтай хангайдаа сүүн сацал өргөв. Тэгээд Балдан туульч “Бүжсин даваа хаан” хэмээх туулийг хэлсэн. Дараа нь Ширэндэв ах “Талын хар бодон” гэдэг туулийг хайлсан. Энэ тууль хаялцах хайлал хоёр өдөр үргэлжилж, тууль хайлж дууссаны дараа найр хийж, Балдан гуай, ах хоёрт тус тусад нь толгой бараа, цайгаар бэлэг барьж байсан гэж Б.Авирмэд сонирхол татам сайхан ёс дэгийг ярьж өглөө.²⁷

²⁷П. Хорлоо. 2007:63-64.